



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/110/НА-СТА-ТШ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2026 оны 02 дугаар сарын 09</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Даваадорж</p> <p>Утас: 90119422 Цахим хаяг: Davaadorjd@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Албан шаардлага	20
5.2 Төлбөрийн акт	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.16 № 2/10

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бараа материалын бүртгэлд байгаа 3,582.5 мянган төгрөгийн мал, амьтан нь тооллогоор биетээр тоологдоогүй бөгөөд бараа материалын бүртгэл бодит байдалтай нийцээгүй байна.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,124,404.4 мянга, орон нутгийн төсвөөс 162,809.2 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 2,682.7 мянга, нийт 1,538,205.9 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,289,896.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

16426050031

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 85 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>309,218,659.20</u>	<u>336,063,390.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,499,832.60	60,145,397.26
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,499,832.60	60,145,397.26
3121	Төгрөг	2,499,832.60	60,145,397.26
31211	Төрийн сангийн харилцах	2,499,832.60	60,145,397.26
33	АВЛАГА	120,578,453.90	97,769,528.53
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	60,906.92	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	120,517,546.98	97,769,528.53
35	БАРАА МАТЕРИАЛ	186,140,372.70	178,148,464.91
351	Түүхий эд материал	85,680,080.42	80,905,507.58
35110	Тусгай зориулалттай материал	56,558,390.01	56,558,390.01
35130	Эм боох материал	29,121,690.41	24,347,117.57
354	Хангамжийн материал	96,627,792.28	93,410,457.33
35410	Бичиг хэргийн материал	1,013,480.00	1,229,500.00
35420	Аж ахуйн материал	93,700,112.28	89,180,357.33
35440	Түлш, шатах тослох материал	122,500.00	00.00
35450	Барилгын засварын материал	33,000.00	33,000.00
35460	Хүнсний материал	860,200.00	2,069,100.00
35470	Бусад хангамжийн материал	898,500.00	898,500.00
35600	Мал амьтад	3,832,500.00	3,832,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,278,686,019.56</u>	<u>3,156,367,678.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,278,686,019.56	3,156,367,678.17
392	Биет хөрөнгө	3,270,750,019.56	3,148,431,678.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,977,713,600.79	2,977,713,600.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	-120,911,960.14	-167,493,147.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	202,785,625.00	202,785,625.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-43,708,624.77	-73,338,968.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	329,879,224.51	312,933,865.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-127,421,616.89	-146,596,618.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,174,041.00	70,211,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,760,269.94	-27,784,178.86
393	Биет бус хөрөнгө	7,936,000.00	7,936,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,936,000.00	7,936,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,587,904,678.76</u>	<u>3,492,431,068.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>33,179,086.10</u>	<u>7,438,531.69</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	33,179,086.10	7,438,531.69
413	Өглөг	33,179,086.10	7,438,531.69
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,827,950.15
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,391,586.10	4,610,581.54
4136	Бусад өглөг	2,787,500.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,787,500.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,554,725,592.67</u>	<u>3,484,992,537.19</u>

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	3,554,725,592.67	3,484,992,537.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	267,139,817.00	267,139,817.00
51101	Өмч: - төрийн	267,139,817.00	267,139,817.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,988,115,200.90	2,918,382,145.42
51210	Өмнөх үеийн үр дүн	2,988,115,200.90	2,988,115,200.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-69,733,055.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	299,470,574.77	299,470,574.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,587,904,678.77	3,492,431,068.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,092,432,277.84	1,276,792,389.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,909,956,060.78	12,326,796.06
120	Нийтлэг татварын бус орлого	2,909,956,060.78	12,326,796.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,000,000.00	2,682,715.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,000,000.00	2,682,715.00
1200044	Үнэ төлбөргүй авсан хөрөнгө	2,814,911,850.40	8,782,100.00
1200045	Үнэ төлбөргүй авсан бараа материал	33,044,210.38	861,981.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,182,476,217.06	1,264,465,593.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,887,200.00	162,809,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,887,200.00	162,809,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,067,589,017.06	1,101,656,393.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,067,589,017.06	1,101,656,393.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,221,915,610.77	1,346,525,444.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,221,915,610.77	1,346,525,444.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,200,557,678.13	1,345,025,444.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,906,628.00	771,707,706.00
210101	Үндсэн цалин	391,003,069.00	447,578,525.00
210102	Нэмэгдэл	224,610,349.00	249,190,451.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,585,000.00	22,615,000.00
210104	Урамшуулал	40,708,210.00	52,323,730.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,189,601.27	91,023,852.46
210201	Тэтгэврийн даатгал	58,344,316.57	59,935,597.89
210202	Тэтгэмжийн даатгал	6,705,066.28	8,335,792.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,154,229.32	5,204,975.51
210204	Ажилгүйдлийн даатгал	3,613,002.94	3,710,751.19
210205	Эрүүл мэндийн даатгал	12,372,986.16	13,836,734.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,999,866.00	159,137,658.44
210301	Гэрэл, цахилгаан	8,500,000.00	15,144,684.44
210302	Түлш, халаалт	110,635,866.00	133,484,474.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	2,864,000.00	10,508,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,690,374.00	56,532,885.01
210401	Бичиг хэрэг	3,181,300.00	4,469,780.00
210402	Тээвэр, шатахуун	30,334,340.00	26,182,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,852,542.00	2,197,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	44,000.00	235,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,278,192.00	23,448,305.01
2105	Нормативт зардал	134,078,985.76	98,992,971.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	121,899,145.76	89,105,271.44
210502	Хоол, хүнс	12,173,840.00	9,887,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,851,174.36	5,801,800.00
210604	Урсгал засвар	7,851,174.36	5,801,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,495,000.00	5,560,000.00
210702	Дотоод албан томилолт	4,495,000.00	5,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,800,378.00	3,956,782.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,123,250.00	1,015,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	362,838.00	421,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,560.00	249,452.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,400.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,294,000.00	2,153,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,545,670.74	152,311,789.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,013,600.00	4,894,648.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,532,070.74	147,417,141.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,357,932.64	1,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,041,900.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,041,900.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	316,032.64	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	316,032.64	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,870,516,667.07</u>	<u>-69,733,055.48</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,870,516,667.07</u>	<u>-69,733,055.48</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,135,806,389.08</u>	<u>1,289,896,326.65</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,000,000.00	2,682,715.00
120	Нийтлэг татварын бус орлого	62,000,000.00	2,682,715.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,000,000.00	2,682,715.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,000,000.00	2,682,715.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,073,806,389.08	1,287,213,611.65
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,887,200.00	162,809,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,887,200.00	162,809,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	958,919,189.08	1,124,404,411.65
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	958,919,189.08	1,124,404,411.65
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,072,606,829.96	1,215,934,061.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,072,606,829.96	1,215,934,061.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,051,248,897.32	1,214,434,061.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,044,719.83	768,993,630.69
210101	Үндсэн цалин	385,361,852.83	458,326,530.87
210102	Нэмэгдэл	221,255,379.00	242,038,628.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,585,000.00	22,380,000.00
210104	Урамшуулал	51,842,488.00	46,248,471.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,438,999.49	90,849,070.70
210201	Тэтгэврийн даатгал	57,298,499.49	61,398,841.70
210202	Тэтгэмжийн даатгал	6,785,100.00	7,507,927.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,392,600.00	3,843,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,392,600.00	3,464,226.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,570,200.00	14,634,276.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,153,743.00	162,809,200.00
210301	Гэрэл, цахилгаан	8,500,000.00	15,144,684.44
210302	Түлш, халаалт	102,353,743.00	137,156,015.56
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.00	10,508,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,756,940.00	46,075,934.00
210401	Бичиг хэрэг	3,125,100.00	4,510,800.00
210402	Тээвэр, шатахуун	30,112,340.00	26,060,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,852,542.00	1,999,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,000.00	235,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,622,958.00	13,070,834.00
2105	Нормативт зардал	99,708,117.00	122,952,996.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,615,137.00	106,048,396.60
210502	Хоол, хүнс	11,641,980.00	11,096,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	451,000.00	5,808,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,090,700.00	8,491,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,614,900.00	2,690,000.00
210604	Урсгал засвар	475,800.00	5,801,800.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2107	Томилолт, зочны зардал	4,495,000.00	5,560,000.00
210702	Дотоод албан томилолт	4,495,000.00	5,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,507,378.00	3,956,782.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,830,250.00	1,015,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	242,798.00	421,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	249,452.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,294,000.00	2,153,500.00
210807	Газрын төлбөр	40,330.00	40,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,053,300.00	4,744,648.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,053,300.00	4,744,648.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,357,932.64	1,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,041,900.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,041,900.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	316,032.64	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	316,032.64	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	63,199,559.12	73,962,264.66
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	113,315,702.50	16,316,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	113,315,702.50	16,316,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	113,315,702.50	16,316,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	113,315,702.50	16,316,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-113,315,702.50	-16,316,700.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-50,116,143.38	57,645,564.66
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,555,350.34	2,499,832.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,499,832.60	60,145,397.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	267,139,817.00	299,470,574.77	2,988,115,200.90	3,554,725,592.67
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	267,139,817.00	299,470,574.77	2,988,115,200.90	3,554,725,592.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	267,139,817.00	299,470,574.77	2,988,115,200.90	3,554,725,592.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-69,733,055.48	-69,733,055.48
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	267,139,817.00	299,470,574.77	2,918,382,145.42	3,484,992,537.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,476,857,600.00	1,232,250,761.99	244,606,838.0	83.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,476,857,600.00	1,232,250,761.99	244,606,838.0	83.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,473,857,600.00	1,230,750,761.99	243,106,838.0	83.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	846,165,500.00	768,993,630.69	77,171,869.3	90.9
210101	Үндсэн цалин	464,671,900.00	459,505,717.87	5,166,182.1	98.9
210102	Нэмэгдэл	276,669,400.00	239,355,913.82	37,313,486.2	86.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,115,600.00	22,380,000.00	4,735,600.0	82.5
210104	Урамшуулал	77,708,600.00	47,751,999.00	29,956,601.0	61.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,491,500.00	90,849,070.70	14,642,429.3	86.1
210201	Тэтгэврийн даатгал	71,019,200.00	61,398,841.70	9,620,358.3	86.5
210202	Тэтгэмжийн даатгал	8,618,000.00	7,507,927.00	1,110,073.0	87.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,309,100.00	3,843,800.00	465,300.0	89.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,309,100.00	3,464,226.00	844,874.0	80.4
210205	Эрүүл мэндийн даатгал	17,236,100.00	14,634,276.00	2,601,824.0	84.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,065,100.00	162,809,200.00	13,255,900.0	92.5
210301	Гэрэл, цахилгаан	16,200,000.00	15,144,684.44	1,055,315.6	93.5
210302	Түлш, халаалт	142,865,100.00	137,156,015.56	5,709,084.4	96.0
210303	Цэвэр, бохир ус	13,000,000.00	10,508,500.00	2,491,500.0	80.8
210304	Урсгал засвар	4,000,000.00	00.00	4,000,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	87,013,600.00	46,075,934.00	40,937,666.0	53.0
210401	Бичиг хэрэг	6,572,900.00	4,510,800.00	2,062,100.0	68.6
210402	Тээвэр, шатахуун	50,434,500.00	26,060,300.00	24,374,200.0	51.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,446,400.00	1,999,000.00	1,447,400.0	58.0
210404	Ном, хэвлэл	150,000.00	200,000.00	-50,000.0	133.3

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,585,000.00	235,000.00	1,350,000.0	14.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,824,800.00	13,070,834.00	11,753,966.0	52.7
2105	Нормативт зардал	155,135,700.00	122,952,996.60	32,182,703.4	79.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128,906,200.00	106,048,396.60	22,857,803.4	82.3
210502	Хоол, хүнс	16,229,700.00	11,096,600.00	5,133,100.0	68.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,999,800.00	5,808,000.00	4,191,800.0	58.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,800,000.00	24,808,500.00	38,991,500.0	38.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	16,504,700.00	2,995,300.0	84.6
210602	Тавилга	5,000,000.00	2,502,000.00	2,498,000.0	50.0
210604	Урсгал засвар	39,300,000.00	5,801,800.00	33,498,200.0	14.8
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	5,560,000.00	2,440,000.0	69.5
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	5,560,000.00	2,440,000.0	69.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,706,800.00	3,956,782.00	6,750,018.0	37.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,980,000.00	1,015,300.00	1,964,700.0	34.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	00.00	850,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	421,200.00	78,800.0	84.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	249,452.00	200,548.0	55.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350,000.00	77,000.00	273,000.0	22.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,476,800.00	2,153,500.00	3,323,300.0	39.3
210807	Газрын төлбөр	100,000.00	40,330.00	59,670.0	40.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21479400.00	4744648.00	16,734,752.0	22.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,479,400.00	4,744,648.00	16,734,752.0	22.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3000000.00	1500000.00	1,500,000.0	50.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	1,500,000.00	1,500,000.0	50.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,500,000.00	1,500,000.0	50.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,471,675,200.00	1,289,896,326.65	181,778,873.4	87.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,295,610,100.00	1,124,404,411.65	171,205,688.4	86.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,065,100.00	162,809,200.00	13,255,900.0	92.5
132001	Орон нутгийн төсвөөс	176,065,100.00	162,809,200.00	13,255,900.0	92.5
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,295,610,100.00	1,124,404,411.65	171,205,688.4	86.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,295,610,100.00	1,124,404,411.65	171,205,688.4	86.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,182,515.00	2,682,715.00	2,499,800.0	51.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,682,715.00	2,682,715.00	0.0	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,499,800.00	00.00	2,499,800.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	2,499,832.60	-2,499,832.6	0.0

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	60,145,397.26	-60,145,397.3	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.0	25.0	1.0	96.2
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25.0	19.0	6.0	76.0
620003	Үйлчлэх ажилтан	0.0	4.0	-4.0	0.0
620004	Гэрээт ажилтан				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлэх хүрээний хүн амд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг орчин үеийн эмчилгээ оношилгооны стандартад нийцүүлэн, жигд, чанартай, хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх зан үйлийг эзэмшүүлснээр хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эх нялхсын өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд ЭМ-ийн яам болон Баянхонгор аймгийн эрүүл мэндийн газраас тус байгууллагад хяналт, шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95,473.6 мянган төгрөг буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,449.8	60,145.4	57,645.6
Авлага	120,578.4	97,769.5	(22,808.9)
Бараа материал	19,189.0	32,357.9	13,168.8
Үндсэн хөрөнгө	3,278,686.0	3,156,367.7	(122,318.4)
Хуримтлагдсан элэгдэл	(311,802.47)	(415,212.9)	103,410.4
Нийт хөрөнгө	3,587,904.7	3,492,431.1	(95,473.6)
Өр төлбөр	33,179.1	7,438.5	(25,740.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,554,725.6	3,484,992.5	(69,733.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,587,904.7	3,492,431.1	(95,473.6)

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 60,145.4 мянган төгрөг болж 57,645.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 97,769.5 мянган төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 22,808.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага орсон нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,357.9 мянган төгрөг болж 13,168.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр 148,791.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 762.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 140,427.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 17,217.9 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж устгасан нь бараа материалын данс буурахад голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,156,367.7 мянган төгрөг болж 122,318.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 19,815.8 мянга, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 5/05 дугаар тогтоолоор 5,283.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 7/42 дугаар тогтоолоор 44,006.7 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг актлах шийдвэр гарсны дагуу данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,438.5 мянган төгрөг болж өмнөх оноос 25,740.5 төгрөгөөр буурсан нь өмнөх оны эмийн өглөг 22,109.4 мянга, түлш халаалтын өглөг 3,631.1 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Тайлант онд 4,610.6 мянган төгрөгийн халаалтын өглөг шинээр үүсч, тооцоо нийлэн баталгаажсан байна. Энэхүү өглөг нь тайлант оны эцэст Төрийн сангаас тогтмол зардлын эрх нээгээгүйтэй холбоотойгоор үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,484,992.5 мянган төгрөг болж 69,733.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үр дүн (69,733.0) мянган төгрөгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 957,748.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 957,748.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 343,044.5 мянган төгрөгөөр өсгөж 1,300,792.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,124,404.4 мянга, орон нутгийн төсвөөс 162,809.2 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 2,682.7 мянга, нийт 1,289,896.3 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,232,250.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,289,896.3 мянган төгрөг буюу 83.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 77,171.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 14,642.4 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 12,255.9 мянга, хангамж бараа материалын зардал 40,937.7 мянга, нормативт зардал 32,182.7 мянга эд хогшил, урсгал засварын зардал 38,991.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 6,750.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 16,734.7 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80302 нэг иргэнд нормативаар	925,343.9	867,270.6	58,073.3	93.7%
2	81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	252,248.5	199,280.7	52,967.8	79.0%
3	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	123,200.1	57,853.2	65,346.9	46.9%

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	176,065.1	162,809.2	13,255.9	92.4%
	Нийт дүн	1,476,857.6	1,287,213.6	189,643.99	87.1%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллага нь хоолны хөнгөлөлт нэг өдөр 5.0 мянган төгрөгөөр тооцож хоолны хөнгөлөлтөд 27,115.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 22,380.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бүтэц орон тоог Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар 28 орон тоог баталсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 26 орон тоо ажиллаж орон тооны цомхотгол хийгээгүй батлагдсан орон тооноос дутуу ажиллаж байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дуламсүрэн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Байгалмаа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 1,300,792.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,007.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 8,455.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 442.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 168,220.0 мянган төгрөгийн 13 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 70 шийдвэрийг бүрэн байршуулсан ба

цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,242,129.7 мянган төгрөгийн 37 мэдээг мэдээлэхээс 1,087,821.9 мянган төгрөг мэдээлж 154,307.7 сая төгрөгийн 9 гүйлгээ мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн мэдээлүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитаар 4,694.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч зөрчлийг тайлант хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг өгсөн. Үүнд:

- Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025.01.20-ны өдрийн тогтоолоор "Марал Баян Өргөө" ХХК-ний эзэмшлийн дулаанаар түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний төсөвт байгууллагад борлуулах эзлэхүүнээр тооцох тарифыг шинэчлэн тогтоосон байна. Тус тогтоолын 2 дах заалтад "Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд"-нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй." гэж заасан ба ЗХХАЭ-д 2025.02.03-д нийтлэгдсэн байхад 2025 оны 01 дүгээр сарын 1-ний эхлэн шинэ тарифаар гэрээ байгуулан 4,694.5 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн тул 2025 оны 12 сарын халаалтын санхүүжилтээс суутган тооцох зөвлөмжийн дагуу суутган тооцож оны эцэст залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,131.0 мянган төгрөгийн нэг зөрчил¹ илэрсэнд 442.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 9,689.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 10,131.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,876.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

5.1.1 Байгууллагын эзэмшиж буй 4 төрлийн 3,968.0 м² газар бүртгэлтэй байгаа бөгөөд дээрх мэдээллийг Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад эмчийн байрны газрын баланс дээрх бүртгэл нь газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)- газрын хэмжээнээс 65м²-аар дутуу зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ГХБХБГ-тай тооцоо нийлж газрын хэмжээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах албан шаардлагыг хүргүүлэв.

5.1.2 Бараа материалын бүртгэлд байгаа 3,582.5 мянган төгрөгийн мал, амьтан нь тооллогоор биетээр тоологдоогүй бөгөөд бараа материалын бүртгэл бодит байдалтай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг комисс томилон нүд үзэн тоож өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн баталгаажуулж зөрчлийг албан шаардлагыг хүргүүлэв.

5.1.3 Эрдэнэцогт сумын ЭМТ нь сумын ИТХ-ын дарга болон Эмийн сангийн захиралтай 10 хувийн хөнгөлөлттэй үнээр эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу нягтлан бодогч, нярав эмийн бүртгэлийг хөнгөлөлттэй үнээр хөтөлсөн боловч ахлах сувилагчийн гаргасан 1–8 дугаар сарын эмийн захиалгын түүвэр тайланд эмийн үнийг хөнгөлөлтгүй үнээр бүртгэсэн нь нярвын тайлангийн зарлагын дүнгээс 6,106.5 мянган төгрөгөөр зөрүү гаргасан байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх", УСНББОУС-12 Бараа материал, НББОУС-2 Бараа материал, "MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эм, эмнэлгийн хэрэгслийг бүртгэлд тусгахдаа гэрээнд заасан хөнгөлөлтийн нөхцөлийг анхан шатны баримтаас эхлэн үнэн зөв, зөрүүгүйгээр бүртгэх, нягтлан бодох бүртгэлийн бүрдэл баримтын уялдааг хангах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлагыг хүргүүлэв.

5.2 Төлбөрийн акт

1. Эрдэнэцогт сумын ЭМТ-ийн даргын А/40 дугаар тушаалаар 442.0 мянган төгрөгийн төсөв баталж төсвийн хөрөнгөөр спортын тэмцээн уралдаан зохион байгуулсан байна.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8 "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах"-ыг хориглох заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг зөрчин зарцуулсан 442.0 мянган төгрөгийн байгууллагын төсөв захирагчаар төлүүлж төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоов.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмшиж буй 4 төрлийн 3,968.0 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд дээрх мэдээллийг Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад эмчийн байрны газрын баланс дээрх бүртгэл нь газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)- газрын хэмжээнээс 65м2-аар дутуу зөрүүтэй байна.	1	-			1	-		
Бараа материалын бүртгэлд байгаа 3,582.5 мянган төгрөгийн мал, амьтан нь тооллогоор биетээр тоологдоогүй бөгөөд бараа материалын бүртгэл бодит байдалтай нийцэхгүй байна.	1	3,582.5			1	3,582.5		
Эрдэнэцогт сумын ЭМТ нь сумын ИТХ-ын дарга болон Эмийн сангийн захиралтай 10 хувийн хөнгөлөлттэй үнээр эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу нягтлан бодогч, нярав эмийн бүртгэлийг хөнгөлөлттэй үнээр хөтөлсөн боловч ахлах сувилагчийн гаргасан 1-8 дугаар сарын эмийн захиалгын түүвэр тайланд эмийн үнийг хөнгөлөлтгүй үнээр бүртгэсэн нь няравын тайлангийн зарлагын дүнтэй зөрүү гаргасан байна	1	6,106.5			1	6,106.5		
Эрдэнэцогт сумын ЭМТ-ийн даргын А/40 дугаар тушаалаар төсөв баталж төсвийн хөрөнгөөр спортын тэмцээн уралдаан зохион байгуулсан байна.	1	442.0	1	442.0				
Нийт дүн	4	10,131.0	1	442.0	1	9,689.0		

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 19/АХТ-БНА-2026/10 -
- МА-СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын бүртгэлд байгаа 3,582,500 (Гурван сая таван зуун наян хоёр наян хоёр мянга таван зуу) төгрөгийн мал, амьтан нь тооллогоор биетээр тоологдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалт, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөрөнгийн тооллогыг комисс томилон нүд үзэн тоож өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн баталгаажуулж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд

6426090063

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүрэг түр орлон гүйцэтгэгч Н.Янжинлхам, нягтлан бодогч С.Байгалмаа нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН*:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР

Д.ДАВААДОРЖ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 20/10571235-БНА-2026/110 -
- НА-ТТН-ТШ!

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмшилд 4 төрлийн 3,968.0 м² газар бүртгэлтэй ба дээрх мэдээллийг Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад эмчийн байрны газрын талбайн хэмжээ нь (egazar.gov.mn)-газрын хэмжээнээс 65м²-аар бага байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж газрын хэмжээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.¹

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

6426090065

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүрэг түр орлон гүйцэтгэгч Н.Янжинлхам, нягтлан бодогч С.Байгалмаа нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР

Д.ДАВААДОРЖ



² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 22/10571455-БМА-2026/110-
- МА-СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн дарга нь сумын ИТХ-ын дарга болон Эмийн сангийн захиралтай 10 хувийн хөнгөлөлттэй үнээр эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулсан ба гэрээний дагуу нягтлан бодогч, нярав эмийн бүртгэлийг хөнгөлөлттэй үнээр хөтөлсөн боловч ахлах сувилагчийн гаргасан 1-8 дугаар сарын эмийн захиалгын түүвэр тайланд хөнгөлөлтгүй үнээр нярвын тайлангийн зарлагын дүнгээс 6,106,500 (зургаан сая нэг зуун зургаан мянга таван зуу) төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх", УСНББОУС-12 Бараа материал, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 "Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх", "үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэл"-тэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

6426090075

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Эмийн түүврийг гэрээний дүнгээр үнэн зөв бүртгэж зөрчлийг арилган, хэрэгжилтийг нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүрэг түр орлон гүйцэтгэгч Н.Янжинлхам, нягтлан бодогч С.Байгалмаа нарт даалгав^{2,3}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР

Д.ДАВААДОРЖ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 6/А057255-БМА 2026/110-
- НА-СТА-ТЦЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас "Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны А/40 дугаар тушаалаар 442,000 (Дөрвөн зуун дөчин хоёр мянга) төгрөгийг спортын тэмцээн, уралдааны зардал зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8 "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах"-ыг хориглох заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн Төрийн хэмнэлтийн хууль зөрчин зарцуулсан 442,000 төгрөгийн (Дөрвөн зуун дөчин хоёр мянга) төгрөгийг Эрүүл мэндийн төвийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Дуламсүрэнгээр нөхөн төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүрэг түр орлон гүйцэтгэгч Н.Янжинлхам, нягтлан бодогч С.Байгалмаа нарт даалгав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР

Д.ДАВААДОРЖ



¹ Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно